

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр					
1	Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжүүлэх	2024.01-р сар	Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжүүлэх	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын 2024 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын 2024 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа. "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын 11 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 98.1 хувийн биелэлттэй байна.	100%
2	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулах	Жилдээ	Албан хаагчид хэрэгцээтэй сургалтад хамруулах	-Нийт 57 удаагийн сургалтад давхардсан тоогоор 239 албан хаагч хамрагдлаа. /эмэгтэй 160, эрэгтэй 79/ Үүнээс албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор Засгийн газрын зорилтод 2 удаагийн сургалтад 3 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 сургалтад 16 удаа, давхардсан тоогоор 144 албан хаагч, Удирдлагын академийн богино хугацааны 5 удаагийн сургалтад 10, Төрийн албанд анх томилогдсоны дараах сургалтад 1, бусад 33 удаагийн сургалтад давхардсан тоогоор 81 албан хаагч хамрагдлаа.	100%

				-Нийт 8 удаагийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хөтөлбөрт давхардсан тоогоор 36 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчидтай хийх уулзалтад 15, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт 8, төрийн ордонд зохион байгуулагдсан "Youth mongolia" залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар чуулганд байгууллагын залуучуудын зөвлөлийн 2 гишүүн, Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал хэлэлцүүлэгт 4, Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганд 3, Менторшин хөтөлбөрт 1, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сан байгуулах уулзалт хэлэлцүүлэгт 1 хаагч хамрагдлаа. Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэгт 2 албан хаагч хамрагдлаа.	
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар сургалтад хамруулах	Жилдээ	2-3 албан хаагчийг хамруулах	-2024 оны 05 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотноо зохион байгуулсан "Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн" арга хэмжээнд 1, 2024 оны 04 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд БНХАУ-д болсон Монгол улс, Улаанбаатар хотыг сурталчлах "B2C" арга хэмжээнд 1, 2024 оны 07 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд Тайваньд зохион байгуулсан "Эко аялал жуулчлал" сургалт семинарт 1, 2024 оны 09 дүгээр 26-29-ны өдрүүдэд Япон улсын Токио хотод зохион байгуулсан олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 1, нийт 4 албан хаагч оролцож, туршлага судалсан.	100%
2. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр					
4	Ажлын хэрэгцээний тоног, төхөөрөмж, тавилгын төсвийг судалж, холбогдох байгууллагад төсвийн саналыг хүргүүлэх	Жилдээ	Төсвийг гаргаж, хүргүүлэх	-Нийслэлийн Аялал жуулчлалын газрыг Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд байрлах нутгийн захиргааны цогцолбор байр руу нүүлгэх ажлыг нийслэлийн Цэргийн штабтай хамтран 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, нүүлгэх зардлыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр шийдвэрлүүлсэн. -Шинэ барилгад нүүж ирсэнтэй холбогдуулан албан хэрэгцээний тоног, төхөөрөмж, тавилгын саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, нийт 15 ширхэг иж бүрэн компьютер, 2 принтер, 10 ширхэг утасны аппараттыг шинээр авч, 3 өрөөнд хөшиг суурьлуулж, байгууллагын гадна болох доторх хаягийг хэвлүүлэн байрлуулсан.	100%

				-Мөн газрын даргын нийслэлийн Өмчийн харилцааны газартай "Нийслэлийн өмч эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулж, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хавсарган хүргүүлэв. -Газрын даргын 2024 оны А/15 тушаалаар байгууллагын үндсэн эд хөрөнгө, бараа материалын 2024 оны тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг баталж тооллогын ажлыг зохион байгуулж байна.	
3.Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах чиглэлээр					
5	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилдээ	Албан хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна	АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран 10 албан хаагчийг эрүүл мэндийн багц үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна.	90%
6	Албан хаагчдад бие бялдар, гоо зүйн төлөвшил олгох соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах.	8-12-р сард	Албан хаагчдын бие бялдар, гоо зүйн төлөвшил сайжирна.	- Албан хаагчдын ажлын ачаалалтай уялдуулан долоо хоногийн 1 өдөр цахимаар ажиллуулж, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуулийн спорт заалыг түрээсэлж, албан хаагчдыг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн. -Албан хаагчдын төрсөн өдөр болон хүүхдүүдийн судалгааг гарган, төрсөн өдрийн хүндэтгэлийг тогтмол үзүүлж байна. Мөн олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан албан хаагчдын 36 хүүхдэд хүндэтгэл үзүүлж, 2,916,360 төгрөгийг зарцуулсан.	100%
4.Албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу цалин хөлс, шагнал урамшуулал олгох чиглэлээр					
7	Албан хаагчдын шагнал авсан судалгааг гаргаж, шагнал урамшуулалд тодорхойлох	6-12 сард	Албан хаагчид шагнал урамшуулалд хамрагдана.	-Байгууллагын албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргасан. Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийг Төрийн албаны зөвлөлөөс олгодог "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр, төрийн дээд хэмжээний шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулсан. Мөн Аялал жуулчлалын өдөр, нийслэлийн өдрийг тохиолдуулан албан хаагчдыг шагнах тодорхойлтыг холбогдох газарт хүргүүлж, 1 албан хаагчийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагчийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Жуух бичгээр, 2 албан хаагчийг	100%

				Нийслэлийн Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагчийг НИТХ-ын Хүндэт үнэмлэхээр шагнуулаад байна. 2 албан хаагчийг төрийн дээд одон медалиар шагнуулах тодорхойлт, анкетийг холбогдох газарт хүргүүлээд байна.	
8	Газрын албан хаагчдын дэлгэрэнгүй судалгааг гаргаж зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүлэх, шийдвэрлүүлэх.	Тухай бүрт	Албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдэл авсан байх	-Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хүрээнд албан хаагчдад цалин, урамшуулал, ээлжийн амралт, илүү цагийн олговрыг тухай бүр олгож байна. Ёс зүйн дэд хорооны 3 гишүүнд урамшуулал олгож, 3 албан хаагчид ээлжийн амралтыг хэсэгчлэн, 12 албан хаагчид ээлжийн амралтыг биеэр эдлүүлж, давхардсан тоогоор 31 албан хаагчид илүү цагийн нөхөн олговрыг олгосон. 2024 оны 06 дугаар сараас албан хаагчдын хоол, унааны мөнгө өдрийн 35,000 төгрөг болон нэмэгдээд байна. -Ахлах түшмэл, дэд зэрэг-1, дэд түшмэл, дэд зэрэг-1, дэс түшмэл, дөтгөөр зэрэг-2 нийт 4 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулж 2 албан хаагчийн төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж 1 албан хаагчийн тангарагыг өргүүлсэн. -Албан хаагчидтай холбоотой 15 төрлийн судалгааг гаргаад байна. - Албан хаагчдын ажлын ачаалалтай уялдуулан долоо хоногийн 1 өдөр цахимаар ажиллуулж байна.	100%
5.Албан хаагчдад тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох чиглэлээр					
9	Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад буцалтгүй тусламж, хөнгөлөлт олгуулах.	Тухай бүрт	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдана.	Буцалтгүй тусламж олгох асуудал гараагүй болно.	100%

10	Албан хаагчдын орон сууцны нөхцөл байдлыг судалж, дэмжлэг шаардлагатай албан хаагчдын санал хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх	Тухай бүрт	Албан хаагчдын нийгмийн асуудал шийдвэрлэхэд тусламж үзүүлнэ.	-Нийслэлийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах судалгааг албан хаагчдаас авч, 11 албан хаагчийн саналыг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. -Мөн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах ажлыг бодитой болгохын тулд орон сууцны дэмжлэг үзүүлэх төсвийг тухайн байгууллагын төсөвт жил бүр эсвэл тодорхой давтамжтайгаар суулгах саналыг нийслэл дэх Төрийн аудитын газрын "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын үеэр гаргаж өглөө. Өнөөдрийн байдлаар нийт 17 албан хаагч ажиллаж байгаагаас түрээсийн орон сууцанд гурав, аав ээжийндээ 2, гэр хороололд 2 албан хаагч амьдарч байгаа бол 5 албан хаагч орон сууцны зээлэнд хамрагдаад байна. 1 албан хаагч орон сууцны санхүүжилтийн дэмжлэг хүссэн албан хүсэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт өгөөд байна.	100%
11	Албан хаагчдын хүүхдүүдийн судалгаа гаргаж, хөгжихөд дэмжлэг үзүүлэх.	Тухай бүртээ	Албан хаагчдын хүүхдүүдийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна.	Судалгаа гаргаж, олон Улсын "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан албан хаагчдын 36 хүүхдэд хүндэтгэл үзүүлж, 2,916,360 төгрөгийг зарцуулсан.	90%
НИЙТ ДҮН					98.1%

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Д.ГАНБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ ДОТООД
АЖИЛ ХАРИУСАН МЭРГЭЖИЛТЭН

 Ш.УНДАРМАА